

ТОМИЛОЛТ: АНУ-н шүүхийн үйл ажиллагаатай танилцсан тухай



Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төв” (Congressional Office for International Leadership – COIL)-ийн “Олон улсын шүүхийн мэргэжилтнүүдэд АНУ-ын шүүхийн тогтолцоо, сайн туршлагыг танилцуулж, улс орнуудын хооронд хууль эрх зүйн хамтын ажиллагааг хөгжүүлэх” зорилготой “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 22-ноос 05 дугаар сарын 05-ны өдрийн хооронд АНУ-ын Холбооны дээд шүүх, Холбооны шүүхийн захиргааны алба, Холбооны шүүхийн төв, Оклахома хот дахь Холбооны баруун дүүргийн шүүх, Оклахома мужийн Дээд шүүх, Давж заалдах шатны шүүх, Оклахома хотын дүүргийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, шүүн таслах ажиллагааны онцлогтой шүүхийн үйл ажиллагаатай танилцлаа.

АНУ-ын шүүхийн тогтолцоо ба шүүгчийн томилгоо.

АНУ нь холбооны болон мужийн гэх хоёр түвшин бүхий шүүхийн тогтолцоотой.

Холбооны шүүх нь Дээд шүүх, 13 Давж заалдах шатны шүүх, 94 Дүүргийн шүүхээс гадна дампуурлын, цэргийн, олон улсын худалдааны, засгийн газрын эсрэг нэхэмжлэлийн, татварын шүүх зэрэг тусгай шүүхүүдээс бүрдэнэ. Холбооны шүүгчдийг



АНУ-ын Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Сенатын баталгаажуулалтаар бүх насаар нь томилдог. Шүүгчдийн ачааллыг хөнгөвчлөх, хэрэг шийдвэрлэх хурдыг нэмэгдүүлэх чиглэлээр холбооны дүүргийн шүүхийн магистрантын шүүгчдийг тухайн шүүхийн шүүгчдийн олонхын саналаар 8 жилийн хугацаатай томилдог бөгөөд тэд хэргийг урьдчилан хянах, нотлох баримт цуглуулах, бага

хэмжээний маргаан шийдвэрлэх зэрэг туслах үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсад 1993-2002 онд ажиллаж байсан туслах шүүгчийн үүрэгтэй ижил төстэй юм.

Холбооны Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Сенат баталгаажуулснаар бүх насаар нь томилдог. Бусад шатны ерөнхий шүүгчээр хамгийн

ахмад шүүгч, эсхүл тухайн шүүхэд хамгийн удаан ажиллаж буй шүүгчийг тодорхой хугацаагаар шүүгчдийн зөвлөгөөнөөр томилдог.

Оклахома мужийн шүүхийн тогтолцоо нь Дээд шүүх, Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүх, Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүх, 77 дүүргийн шүүхээс бүрдэнэ.

Мужийн Дээд шүүх болон Давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг Шүүхийн нэр дэвшүүлэлтийн комисс (Judicial Nominating Commission)-ын санал болгосон 3 нэр дэвшигчээс мужийн амбан захирагч 6 жилийн хугацаатай томилдог. Харин 6 жилийн хугацаа дуусгавар болсны дараа шүүгчийг тухайн албан тушаалд дахин улираах эсэхийг сонгогчдын санал асуулга (retention election)-аар шийддэг бөгөөд энэ нь өрсөлдөгчгүй, зөвхөн улираах эсэхийг тодорхойлдог онцлогтой.

Харин дүүргийн шүүгчийн хувьд Шүүхийн нэр дэвшүүлэлтийн комисс (Judicial Nominating Commission)-ын санал болгосноор мужийн амбан захирагч томилдог, эсхүл сонгуулиар (partisan election) сонгодог холимог томилгооны загвартай.

Мужийн бүх шатны ерөнхий шүүгчийг шүүгчдийн зөвлөгөөнөөр 1-2 жилийн хугацаатай томилдог.

Засаглал хуваарилалтын онолын хувьд, АНУ-ын шүүгчийн томилгооны тогтолцоо нь шүүхийн бие даасан байдлыг хангахад чиглэдэг. Гэхдээ мужийн түвшинд сонгууль болон санал асуулгад үндэслэн шүүгчийг томилдог нь улс төрийн нөлөөнд хэт автах эрсдэлтэй гэж шүүмжлэгддэг байна.

Шүүгчийн ажиллах орчин ба нийгмийн баталгаа.

Аль ч шатны шүүхийн шүүгч нь 3 туслахтай ажилладаг бөгөөд туслахууд нь шийдвэр бичих, судалгаа хийх, хэргийн хөдөлгөөнийг удирдах, шүүх хуралдааны бэлтгэл хангах, тэмдэглэл бичих зэргээр дагнан ажилладаг.



Шүүгчийн ажлын байр нь туслахуудын өрөө, ажлын өрөө, цайны өрөө, номын сан, зөвлөлдөх тасалгаа, шүүх хуралдааны танхимтай шууд холбогдсон зохион байгуулалттай.

Шүүгч нь насан туршийн томилгоотой тул тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн ч ажлаа үргэлжлүүлэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд хэрэг хуваарилалтын ачааллаа өөрөө тодорхойлдог.

Холбооны шүүхийн төв нь холбооны шүүхийн түвшинд шүүхийн сургалт, судалгаа, олон улсын хамтын ажиллагаа, шүүхийн түүх судлалыг хариуцан ажилладаг. Шүүгчдийг заавал сургалтад хамруулах шаардлага тавьдаггүй бөгөөд хэрэгцээнд суурилсан, уян хатан сургалтыг цахим болон зайны хэлбэрээр санал болгодог. Мөн шүүгчдэд зориулсан хялбар гарын авлага, тухайлбал нотлох баримтын хуваарилалт, шийдвэр бичих арга зүй, шүүх хуралдаан удирдах техник, хиймэл оюун ухааны хэрэглээ зэрэг сэдвээр гаргадаг байна.



Зураг: Оклахома мужийн Дээд шүүхийн байр.

Оклахома муж дахь шүүхүүдийн шүүн таслах ажиллагааны зарим онцлог:

- Оклахома мужийн Давж заалдах шатны шүүх хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх, эсвэл бичгийн баримтад үндэслэн шийдвэрлэх (summary disposition) гэсэн хоёр хэлбэрээр хянана. Зөвхөн бичгийн баримтад үндэслэн хэрэг шийдвэрлэж буй нь цаг хугацаа, зардлыг хэмнэдэг.
- Шүүгч шийдвэр гаргах буюу зөвлөлдөх үйл явц нь хэд хэдэн онцлогтой. Тухайлбал, ихэнх тохиолдолд шүүгч шүүх хуралдааны хэлэлцүүлэг дуусгавар болох үед зөвлөлдөхгүйгээр шууд шийдвэрээ танилцуулах, зарим тохиолдолд зөвлөлдөх тасалгаанд зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрээ гаргадаг мөн хэргийн ээдрээ төвөгтэй байдал, маргааны онцлогоос хамааран шүүх хуралдаан дуусгавар болсноос хойш шийдвэрээ хожим гаргах тохиолдол байдаг.
- Шийдвэрийг бичгээр албажуулж гарах хугацааны хувьд бага үнийн дүн бүхий хэргийн шийдвэр зөвхөн маягт бөглөх байдлаар гардаг. Харин бусад хэргийн

хувьд мөн л маргааны онцлог, шүүгчийн ачааллаас хамааран 14 хоногоос 6 сар хүртэлх хугацаатай байна.

- Оклахома мужид гэрлэлт цуцлалтын хэргийн 60% (3/5) нь шүүхэд ханддаг бөгөөд эдгээрийн 70% (7/10) нь эвлэрүүлэн зуучлалын шатанд шийдвэрлэгддэг.

Энэ амжилтын үндэс нь child-centered mediation буюу хүүхэд төвтэй зуучлалын хөтөлбөр хэрэгжүүлдэг, гэр бүлийн хэргийн зуучлагчид тусгай сургалтад хамрагдсан, гэр бүлийн хууль, сэтгэл зүй, хүүхдийн хөгжлийн чиглэлээр мэргэшсэн байдаг. Зуучлагчид сайн дурын үндсэн дээр ажилладаг нь нийгмийн хөгжил, хууль эрх зүйн соёлтой холбоотой.

Монгол улсад 2024 онд гэр бүлийн эрх зүйн 3,826 өргөдөлд эвлэрүүлэн зуучлал явагдсанаас 472 (12.3%) нь амжилттай, 3,354 (87.7%) нь амжилтгүй болсон тул хүүхэд төвтэй зуучлалын загварыг нэвтрүүлэх, эвлэрүүлэн зуучлагчдыг Гэр бүлийн хууль, сэтгэл зүйн чиглэлээр мэргэшүүлэх сургалт явуулах нь Монголын гэр бүлийн хэргийн зуучлалын амжилтыг нэмэгдүүлж болохоор байна.

- Мөн гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд хүүхдийн асрамжийн талаар маргасан цагаас эхлэн шинжээч томилдог.

Шинжээчийн шинжилгээ хийх үйл явц нь шүүхээс хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд үргэлжилдэг. Энэ хугацаанд шинжээч нь эцэг, эх, хүүхдийн амьдран буй газар, ажил, сургууль, цэцэрлэг, хамрагддаг олон нийтийн хөтөлбөр зэрэг бүхий л амьдралын хэв маяг, хүрээллийг судалсны үндсэн дээр дүгнэлт гаргадаг.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдах гэж буй, мөн 2026 оноос энэ төрлийн хэргийг дагнан шийдвэрлэх шүүх байгуулагдах гэж буй энэ цаг үед бид гэр бүлийн хэрэг маргаанд шинжээчийн оролцоог эрт эхлүүлэх, дүгнэлт гаргах цар хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна.

Одоогийн шүүхийн практикт хүүхдийн асрамжийн асуудлаар шинжээчийн дүгнэлт гаргах үйл явц ихээхэн учир дутагдалтай байгааг энэ салбарт ажиллаж буй хэн бүхэн, мөн шүүхээр маргаанаа шийдвэрлүүлсэн иргэд ч тодорхой мэдэж буй за.

- Оклахома мужид Order of Protection буюу гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг богино хугацаанд шийдвэрлэдэг. Энэ төрлийн хэрэг нь гэр бүлийн хүчирхийлэл, дарамт, эсвэл аюул учруулж болзошгүй заналхийлэл зэргийг хамардаг тул хохирогчийн аюулгүй байдлыг хамгийн түрүүнд хангахыг зорьдог.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг шүүх 14–30 хоногийн дотор бүрэн шийдвэрлэдэг. Түр хамгаалах захирамжийг өргөдөл ирснээс 24 цагийн дотор гаргадаг бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх үндсэн хуралдааныг үүнээс 14 хоногийн дотор хийдэг. Хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа нь маш шуурхай, төлөвлөгдсөн байдлаар зохион байгуулагддаг тул шүүх хуралдаан нь дунджаар 2–5 минут үргэлжилдэг. Шүүгч шийдвэрээ бичгэн хэлбэрээр хурал дээр шууд гаргаж талуудад гардуулдаг. Ийнхүү гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг хурдан хугацаанд шийдвэрлэж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэний аюулгүй байдлыг нэн даруй хангах, цаашид гарах эрсдэлийг бууруулах, хохирогчийг дахин давтагдах гэмт үйлдлээс хамгаалах үндсэн зорилготой байна.

Оклахома муж дахь шүүхүүдийн ил тод байдал, цахимжилт.

- Цахим хавтаст хэргийг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлж хэвшсэн байна. Иргэдээс эхний ээлжид шүүхэд нэхэмжлэлийг заавал цаасаар өгдөг. Үүнийг нэхэмжлэгч, хариуцагчийн үнэн зөв байдлыг баталгаажуулах зорилготой гэж тайлбарладаг.

Харин ийнхүү нэхэмжлэлийг хүлээн авснаас хойших бүхий л ажиллагаа цахимаар “e-filing” систем дээр явагддаг. Тодруулбал, хариу тайлбар гаргах, хүсэлт гаргах, нотлох баримт гаргах зэрэг. Талууд нотлох баримтыг эргэлзээтэй, худал гэж маргаагүй бол цахимаар оруулсан нотлох баримтыг шүүхэд цаасаар авахгүй, зөвхөн цахим хэлбэрээр нь үнэлнэ.



Хэргийн оролцогчийн гаргасан хүсэлтийг шүүгч шийдвэрлээд талуудад хүргүүлэхгүйгээр “e-filing” системдээ байршуулна. Мөн шүүхээс гарсан шийдвэрийг мөн цахимаар оруулна.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч нь нэхэмжлэл өгөх, шүүх хуралдаанд оролцох үедээ шүүхэд хүрэлцэн ирнэ.

- Оклахома мужийн “e-filing” системийн нэг онцлог бол хэргийн бус оролцогч тухайн хэргийн талаарх мэдээлэл, баримттай танилцах нь нээлттэйд оршдог. Үүнд гэр бүлийн маргааны баримт мөн хамаардаг гэж танилцуулсан.
- Шүүх хуралдаан бүхэлдээ нээлттэй явагддаг. Анхан шатны шүүх хурлуудад тухайн шүүгчийн тэр өдөр шийдвэрлэх хэргийн бүх оролцогч шүүх хуралдааны танхимд ээлжээ хүлээж суухдаа өмнөх шүүх хуралдаануудыг ажигладаг. Гэр бүлийн хэрэг маргааныг ч мөн ийнхүү хөндлөнгийн бусад этгээд ажиглах нь нээлттэй байсан.

Үндсэндээ төрийн нууцтай холбоотой биш л бол бүхий л хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нийтэд нээлттэй. Цөөн тохиолдолд насанд хүрээгүй оролцогчтой хэргийн шүүх хуралдаан хаалттай явагддаг болохыг тайлбарласан.

Эндээс аливаа улсын шүүх нийтэд ил тод, нээлттэй байх чиглэл рүү чухалчлан анхаарч буйг шүүгчид соргоогоор хүлээн авч үйл ажиллагаанд нэвтрүүлэх цаг болсон нь харагдаж байна. Үүний нэг илрэл нь манай улсад шүүх хуралдааныг шууд дамжуулах, бичлэгийг цахим орчинд байршуулах ажиллагаа болж байна. АНУ-ын Холбооны дээд шүүхийн хувьд сонирхсон аливаа иргэн үйл ажиллагаатай, шүүхийн байртай танилцах нь чөлөөтэй байдаг.

- Шүүхүүд номын сан хөмрөг, муж улсын бүх жишиг шийдвэрийн санг бүрэн цахимжуулсан байна. Ингэж хэрэг маргааныг шийдвэрлэхэд жишиг болох шийдвэрийг цахим сангаас хайдаг болсноор их цаг хугацаа, зардал хэмнэгджээ.
- Мөн сүүлийн үед өмгөөлөгчид шүүхэд тайлбар, хүсэлт гаргахдаа хиймэл оюун ухаан ашиглах нь ихэссэн байна. Харин шүүгч нарын хувьд үүнд ихэд болгоомжтой хандаж ёс зүйн болон хууль эрх зүйн хүрээнд хатуу зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж буйгаа илэрхийлсэн.
- Зарим тохиолдолд шүүх хуралдаанд хэргийн оролцогчийн саналыг харгалзан орчуулагчийг цахимаар оролцуулдаг. Орчуулагчийн эрхийг шүүхээс олгодог нь энэ төрлийн хэрэгцээ шаардлагатай иргэдийн шүүхэд хандах боломжийг нэмэгдүүлсэн.

Эрх зүйн хөгжлийн үр дүнд одоо эрх зүйн бүл хоорондын ялгаа арилж, аль хэрэгтэй гэсэн зохицуулалтыг бүл харгалзахгүйгээр нутагшуулдаг болсон тул дээр дурдсан зарим туршлагуудыг бид практикт нэвтрүүлэх бүрэн боломжтой билээ.

Нийслэлийн Иргэний хэргийн давж
заалдах шатны шүүхийн шүүгч Т.Бадрах